

ДУУНЫ ЯРУУ НАЙРАГ БУЮУ

“МОНГОЛ ХОДООД”

Д. Цэнджав

Дуу хөгжим гэдэг бол тэр чигээрээ гоо сайхан, хүний сэтгэл зүрхэнд ид шидтэй нэвтрэн ордог ер бусын урлаг. Сэтгэлийн гайхамшигт хөдлөлийн зөвхөн дуунд л шингээж болдог. Дуу хүнээс урвашгүйгээр дархлагджээ. Сүүлийн үед манай хөгжмийн зохиолчид, ая зохиогчид, дуучид өөрсдөө “Битгий гоё урансайханжуулаарай, битгий гоёор хэлээрэй, битгий дүрслээрэй, зүгээр маш энгийнээр та бид хоёрын энэ ярьж байгаа шиг борог бааз үгээр хийгээрэй” гэдэг болсон. Хэдхэн энгийн үг хэлхээд өгөхөд “Давай, энэ чинь алаад өгч” гэнэ. Яахав эгэл энгийн байна гэдэг бол бүтээн туурвихын бас нэгэн шидэт зүйл мөнөөс мөн. Тиймдээ ч Гамзатов “Хамгийн сайн ваарыг энгийн шавраар хийнэ, хамгийн сайн шүлгийг энгийн үгээр бичнэ” гэж хэлсэн. Энгийн гэдгийг бохир зүйлээс ялгах хэрэгтэй. Энгийн байна гэдэг яг байгаагаараа байгаа амьдралын хуулбар, болхи толхи үгийн цуглуулга биш. Энгийн үгүүд оюун тархины шүүлтүүр, дамжлагаар яван явж, “цэвэрлэгдээд гарч ирэхдээ жинхэнэ үзэмжит, энгийн гоо үзэсгэлэнт илэрхийлэл болоод гараад ирдэг. Далдын далд гоо сайхан. Яруу сайхны дотоод мөн чанарыг ташаагүй үнэнээр хэлээд ирэхлээр үүнийг эгэл энгийн байна, гоё байна гэгцгээдэг. Энгийн өөрөө эгэл бусын чанарыг хадгалдаг. Хүн хэлэх гээд чадахгүй, аман дээр нь тороод гарахгүй байгаа тэр зүйлийг л хэлчихлээр энгийн байна гэдэг.

Гүн завхралд орсон, үүнийгээ мэдрэхээ больсон энэ цагийн оюун санааны хамгийн доройтол бол дууны үг, шүлэг юм. “Шар хэвлэл” гээд сүрхий эгдүүцэн шуугицгаадаг боловч “дууны шар үг хэллэг” гэж хэлэхийг сонсоогүй. Жинхэнэ үг хэллэгийн завхайрал, чөлөөт янхдалт, орь залуусыг оюуны солиоролд оруулах хог новш түүгээр чихээстэй байгааг харах нүд, мэдрэх сэтгэл алга. Аялгуу хөгжим нь авч яваа тул үгийг тэр бүр шүүхгүй, номын хуудсанд байдаггүй болохоор шинжээчийн шүүлтүүрт ордоггүй, тэгээд ч дууны шүлэг, найргийг судалдаг мэргэжлийн шүүмжлэгч байхгүй учраас дураараа дургих салбарын нэг болжээ. Туурвилзүйн “Аа” ч байхгүй нялх хамтлагийнхан шар айргаа гүзээлэх хоорондоо балай балай үгээ тал талаас нь цуглуулж овоолон шавж, нэг дуу ухаантай юм гаргадаг ажээ. Түүнийхээ аяыг голдуу америк болоод баруунаас жаахан хувиргаж дэлсээд юм хийчихэж байна. Үүнийг ойлгохгүй нөгөө “фэнүүд” гэгч нь орилж чарлаж сүйд болцгооно. Ингээд ганц хоёрхон дуутай болоод бие даасан тоглолтоо хийж, энд тэндээс худал хөөргөдсөөр төдхөн од болцгооно, пээдийцгээнэ. Энэ бол “оддын өвчин.” Ямар юмных нь од байхав дээ. Дор хаяж гурав дөрвөн бие хамгаалагчтай, хаа дуртай газраа нисээд оччихдог нисэх онгоцтой, хэдэн арван мянган хөгжөөгчидтэй, заримыг ухаан алдуулж өвчин эмгэгтэй болгож байж өөрсдийгөө од гэвэл болох л юм. Түүнээс биш тасалбараа байгууллага, танил тал, ах дүү,

найз нөхдийгөө тамлан байж шахна. Хөөрхий анх удаа урлагт хөл гишгэхэд ингэхээс ч өөр аргагүй. Би үүнийг шилдгийн шилдэг хамтлагуудад, шилдэг дуучдад зориулж байгаа юм биш үү. “Хүүхэд ийм насан дээрээ хөөрхөн байдаг” тэр л хэсэгт зориулж байгаа юм.

Хэлний найруулга зүйд “өргөө” гэсэн эрхэмсэг найруулга, “гэр” гэсэн ерийн найруулга, “овоохой” гэсэн доромж найруулга байдаг шиг дууны туурвилзүйд үг, шүлэг, яруу найраг гэсэн гурван зэргэмж баймаар санагддаг. Дуу үг одоо ид хүчээ авч байна. Гудамжны “нус нуимс” шиг бохир заваан үгс тэр чигээрээ дуунд орж иржээ. Үүнийг бол “үглэл дуу” гэх бөгөөд “репийнхэний” гол шиддэг чулуу. Нэг иймэрхүү үгтэй реп дуу чих дэлссэн. Охидын нэг хамтлаг муусайн хөвгүүдийг ёстой “яйруулж” байнаа. “Муусайн өмхий амтай бацаанууд, чулуугаар тархийг нь хага цохивол таарна” юу юу ч билээ, хараал зүхэл тэр чигээрээ орсон байхыг сонссон. Ингэж үе үеийнхнээ гутааж болохгүй биз дээ, охид нь хөвгүүдээ үзэн ядаж болохгүй. Үүнийг дахиад сонсоод үг бүрийг бичиж авъя, олны жигшилд хүргэе гэсэн боловч тааралдсангүй. Энэ чинь FM-ээр явж байсан олон түгсэн, бараг захиалгаар явсан дуу шүү. Энэ бүх бадайрлыг хэлээд яхав.

Дууны шүлэгт тэр энгийн гоо сайхныг шингээсэн, ёстой л дуучид, хөгжмийн зохиолчдын тавьдаг шаардлагыг тавьж болох юм. Гэхдээ би “шүлэг” гэдгийг муутгаж байгаа юм биш шүү. Л. Түдэв гуай “Хөх жавар” номын өмнөх үгийг бичихдээ “ШҮШ” уул гэж нэрлээд, “шүлэ., шүлэгч” гэдэг үгийн учрыг тайлж тайлбарласан. Энэ нь шүүмжлэгч, үгүүлэгч, шүлэгч гэсэн үгийг үсгээр толгойлон бүтээсэн зохиогчийн нэгэн уран сэтгэмж л дээ. “Яруу найраг, яруу найрагч” гэсэн үг монголын эртний болоод дундад эртний үеийн утга зохиолд ер байгаагүй зүйл. Харин “шүлэг, шүлэгч” гэсэн үг чинь жинхэнэ монгол хэлэнд, жинхэнэ эртний утга зохиолд байсан зүйл. Манай заримууд жараад онд Горькийн сургууль төгсч ирээд баахан омогшиж, “шүлэгч” гэхлээр ядуу буурай сонсогдож байна, бид яруу сайхны дээдийг бүтээх ёстой, үүнд таарсан үг томьёолол нэр хэрэгтэй гэлцээд “яруу найраг, яруу найрагч” гэдэг үгийг зохиож олсон юм” гэж хэлсэн. Юмыг айхтар гярхай ажигладаг, нээдэг, бясалгадаг эрдэмт хүний үг шүү. Үнэндээ “яруу найрагч” гэхлээр мань мэт нь бөхөөр бол цоллуулж байгаа шиг цаанаа л бишүүрхмээр, ичмээр сүртэй дуулддаг, санагддаг. “Зохиолч, сэтгүүлч, шүүмжлэгч” гэвэл ингэж цэрвэх зүйл огт байхгүй. Үнэн юм чинь. “Яруу найрагч” гэдэг үг хөөргөн, гялалзуур үг биш л дээ, хүндэтгэл мэт сонсогддог. Таарсан эзэндээ бол жин тан яг тохирсон үг. Шүлэг бүтээл туурвилаараа хаан мэт хоймор эзэгнээд суучихсан, ард түмний хайртай хүмүүсийг ингэж дуудах нь нэн зохимжтой бөгөөд эерүү дулаан сонсогддог. “Шүлэгч Явуухулан, Пүрэвдорж” гээд дуудвал юу болохов. Цоо шинэ үг шинэ дээл шиг биед эв хавгүй байж байгаад төдхөн эвтэйхэн болдог шиг эхлээд чихнээс гадуур сонсож байгаад мөд хэвшээд тэр үгийн талаар бодохоо больдог. “Шүлэгч” гээд эхнээсээ явчихсан бол ер янз бүрийн юм бодогдохгүй. Харин бөхийн аманд гарч байгаа шодон залууг “яруу найрагч” гэж дуудаж байгаа нь алдрын алтан титмийг жижигхэн толгойд өмсгөж байгаа шиг бодогддогоо ташрамд хэлье. Одоо манай постмодернистуудыг “яруу найрагч” гэж байгаа нь тэдний хувьд бараг л басамжлал мэт сонсогдож магадгүй. Энэ хүмүүс үгийн урлаг гэгчийг гойд чухалд үздэггүй, зөн билэг мэдрэмжид илүү найдаж, хэл найруулгын эвдрэл, үгийн хэлхээ холбооны зөрчлийг нэгэн урлал зүйл болгодог болоод тэр. Нэн ялангуяа гоё ганган үгийн эсрэг дайн зарладаг улс шүү дээ.

Гурав дахь дуу яруу найраг гэж ярьвал зохистой нэгэн туурвилзүйл байна. Энэ бол чихнээ сонсголт, яруу тансаг, төгсжил бүрэлдсэн, сэтгэлээс гарахааргүй үг

хэллэгтэй тансаг орчныг бүрдүүлэгч юм. Ардын ухаанаас үүдэлтэй, үй олон ухаант ардуудаар шүүгдсэн ардын дуу энэ төрөлд хамаарна. Энэ бол ариусахуй, яруусахуй юм. Үүнийг гүн мэдрэмжтэй, яруу тансаг үг, төгс төгөлдөр утгыг эзэмшиж чадсан авъяастнууд хийж чадна. Тийм авъяастнууд дууны яруу найраг руу уорохгүй байна.

Яруу найргийн гоо сайхны ойлголт зөрөлдөөнтэй болжээ. Түүнийг эс тоох биш, бүр үгүйсгэж, цаашилбал бүр үзэн ядах шинжтэй болчихлоо. “Гоо сайхан, гоо зүй” гэсэн балай юмыг бүү ярь, шүлэг уран бүтээлд гоо сайхан гэгч хумсын төдий ч хэрэггүй, тэр бол балайрал, хоцрогдол, гоо сайхны онол ч гэж байхгүй, юу бодсоноо бич, бүүр хөгийн юмыг ч бич, урлаг утга зохиолоос гоо сайхныг шаардаг цаг үе өнгөрсөн, юуг ч яаж ч бичиж болно” гээд оюутнуудын уулзалтын үеэр хэлж байхыг сонсов. Хиргүй, тортоггүй цэвэр тархийг ингэж угааж, хордуулах гэж дээ гэхээс түүнд биш энэ цаг үед гайхшрахад хүрч билээ. Би шүлэг бүрээс гоо сайхныг нэхэгч, шаардагч биш. Зүй тогтлоороо л бүтээлээ туурвиж явахад юу нь гээгдэж, юу нь гарч ирэх, юу нь сөнөж, юу нь мандал дээгүүр хөвөх нь уран бүтээлчийн эрх чөлөө.

Үнэхээр гоо сайхан, гоо зүй гэгч юусан билээ? чи өөрөө түүний тухай бодож бичиж байсан уу? гэж анх удаа эргэцүүлэв? Үнэндээ ч үүнийг гоо зүйтэй бичих хэрэгтэй гэж бодож байсангүй. Гоо зүй гэгч зохиомол зүйл биш, төгмөл зүйл. Бодлогогүйгээр зохиолч шүлэгч өөрөө жирэмсэлсэн байх учиртай ч юмуу? ерөөс зохиолчийн урлал, хийц, ур чадвар юм. Бичих явцад хачин юмс орж ирэлгүй яахав. Бохир юмаа, яаж аятай болгох вэ? гээд “зүлгүүрддэг” юм маань л мөнөөх гоо сайхан бололтой. Хэний ч шаардлагагүйгээр, хэний ч номлолгүйгээр миний сэтгэл зүрхэнд өөрөө суусан дархлаа байсныг сая л олж мэдрэв. Ялгас зам мөр дээр байвал түүнийг гишгэхгүй тойрч гарахаа мэдэхтэйгээ шиг бохир, заваан, ой гутам, гутамшгийн муу муухайг яаж цэвэр цаасан унагаж зүрхлэнэ вэ? Гэвч би өөрөөсөө дандаа яруу сайхныг, гэрэл гэгээг хүсэж байсангүй, тэгж бодоогүй санаандгүй зүйл маань гоо сайхан болж байсныг ойлголоо. Хэлэх үг бүхэн хэмжээтэй. Сайхан муухай хэмжээтэй. Сайн муу хэмжээтэй. Нулимс инээд хэмжээтэй. Энэ хэмжээгээ мэдрэхээ байгаад, төсөөлөхөө болиод өөрийгөө хянах ухаангүй болоод ирэхлээр л зам дээрх өмхий ялгас дээр гишгэдэг юм байна. Ийм эвгүй үнэр бүр нэртэй, алдартай зохиолч найрагчийн бүтээлээс ч хаа сайгүй үнэртэнэ. Бид өөрсдийгөө болоод уншигчаа, монголын оюун санааг хүндлэх хэрэгтэй. Нэгэн эмэгтэй шүлэгчийн номын хуудас бүрээс янханы газрын хаалга хяхнахыг сонссон. Яахлаараа гоо сайхны эх дагина болсон бүсгүй хүний тархинд ийм үгс ордог, ийм юмыг аймшиггүй зоригтой хэлж чадаж байна. Үүл борооны явдалгүй холвиудын кино байхгүй гэдэг. Магадгүй энэ нь роман шиг том төрөлд амтат бялуу болдог, уншигчаа уйдаж залхаахгүйн төлөө үүнийг бичихээс өөр аргагүй болдог. Энэ бол зохиолч бүхэнд тохиолдог зүйл. Гэвч үүнийг яаж улаан цайм илэрхийлэхгүй байх вэ? яаж өнгийг бууруулах вэ? гэж утга далдлах, цухуйлгаад орхих, гуйвуулсхийх зэргээр хандаж болдог.

Гоо зүй гэгч юусан билээ? “Гоо зүй гэгч мэдэрч танин мэдэхүйн тухай шинжлэх ухаан” гэж гоо зүйн анхны номыг бичсэн германы соён гэгээрүүлэгч А. Г. Баумгахртнер гэгч аль амбасын үеийн 1750 онд биччихсэн байх юм. Агуу их урлагаас л, агуу их утга зохиолоос л гоо сайхан гэгчийг нэхэхгүй бол өөр юунаас нэхэх юм бэ? анхилуун үнэрт сарнайг номын бүх хуудас болгоноос үнэртэх ёстой гэж тулгахгүй. 35000-10000 жилийн өмнөөс л балар эртний хад чулуун дээр үлдсэн сүт зураг, ертөнцийг өөрөөр харах гэсэн оролдлого гарч байжээ. Энэ бол байгаа амьдралыг биш, байхгүй гоё амьдралыг тархиндаа ургуулж эхэлсэн танин мэдэхүй яах аргагүй мөн.

Аль манай тооллын өмнөх агуу Аристотель гэгч дэлхийн уран зохиолын туурвилзүйн эцэг юу хэлсэн билээ? Тэрбээр туурвилзүйд “ариутгахуй” гэдэг ухагдахууныг ихэд цохолсон байх юм. “Хүний сэтгэлийг ариутгах энэ юу вэ? Бас сайхан гэдэг хэмжээ, дэг журам хоёрт байдаг” гэсэн. Нөгөө л миний түрүүчийн хэм хэмжээний тухай. Гоо сайхан гэгч сэтгэл мэдрэлийн дээд үнэлэмж гэж боддогсон. Гэвч дандаа сайн сайхан, гайхамшиг, яруу үзэсгэлэн бишээ. Зөгийн бал амттай ч дангаар нь халбага халбагаар нь идэж болохгүй. Бурмыг ч ялгаагүй. Муу муухай эмгэнэл бий. Гашуун бүхэн амттай байдаг. Шүүмжлэл хэцүү ч үнэн л бол заавал амьдралд тусалдаг. Магтаал, сайн сайхнаас сүүнд дусал төдий унасан эмгэнэл илүү сургамж өгдөг болохоор эмгэнэлт жүжиг, тууж, романыг үгүйсгэхийн аргагүй.

Гоо сайхныг бич, гоо сайхантай харуул гэж өнөөдөр хэн ч шаардахгүй. Тэгвэл зөрчилгүйн онол дахин сүүтийтэл босоод ирнэ гэсэн үг. Муу муухай юмс үзэгдэл сайн сайхнаасаа илүүтэй хүний сэтгэлд сүүдрээ илүү унагадаг болохоор хэзээ ч санаанаас гардаггүй. Тиймээс грек, ромын утга зохиолд “эмгэнэлт явдлыг гүн гүнзгий тусгах нь яруу найргийн оргил” гэж үздэг байжээ. Сөрөг үзэгдэл болох эмгэнэл, гашуудал, хилэгнэл, гутамшиг, муу бүхэн амьдралд бий.

“Ертөнцийг гоо сайхан аварна” гэж АП. Чехов хэлчихсэн. Үүнийг их холоор бодвол юм юм гарч ирнэ. Урлаг утга зохиол бүхэлдээ гоо сайхан гэж Аристотель нээсэн. Чернышевский “Гоо сайхан бол амьдрал юм. Амьдралаас гадагш жинхэнэ гоо сайхан байхгүй” гэжээ. Гоо сайханд үнэнч байхыг тунхагласан. Демокрит “Гоо сайхан бол бүх талаар зохист хэмжээ юм” гэсэн. Гоо сайхан бол бадрангуй болоод эмгэнэл юм. Нээгдэшгүй зүйлийг гоо сайхан нээнэ. Яасан гоё үнэртэй юм бэ? Ямар гайхамшигтай юм бэ? Ямар их азтай юм бэ? гэхчилэн сэтгэлийг догдлуулах дээд зэргэмжийн чанар. Сэтгэлзүйн гоо өдөөгч юм. Гоо сайхны хаалга үүд нь харах, сонсох, хүртэх, үнэртэх, амтлах. Гоо сайхны мэдрэмжгүй бол яавч яруу найрагч болохгүй ээ. Л. Н. Толстой “Сайхан гэж юу вэ? Тайлбарлах хэрэгцээгүй бөгөөд бололцоогүй” гэсэнсэн.

Гэтэл гоо сайхан хэрэггүй гэдэг мунхаглал болжээ. Ой гутам огиудас хүрэм юмыг эрээчиж байна. Энд зах замбаараа алга. Жинхэнэ натурализм. Жинхэнэ бохир усны хаягдал шиг, нус цэр шиг бөөлжис шиг, ядгадас шиг зүйлийг яавч өргөж өршөөж болохгүй. Шүлэг яруу найргийн хуудсанаас янз бүрийн юм үнэртэг хамаагүй, гэхдээ л

арай ч хэтэрнээ гэхээр юм их байнаа. Гоо сайхан хэрэггүй гэсэн энэ юуных нь онол байхав. Тэр болгон шаардлагагүй гэж болох байх. Энэ нь хэмжээ хязгааргүй болхи завааныг бий болгожээ. Үй олон жишээ бий. Хэдэн жилийн өмнө “Монгол ходоод” гэдэг дууг тайзнаас дуудахыг сонсоод итгэж ядав. Ийм муухай доромжлол, ийм муухай балайрал гэж байхаа бас, энэ зуунд. Тэнд суугч бүдүүн бүдүүн эрчүүд хоолойдоо тулж ирсэн гулгидасаа гаргачих алдан цатгалдан инээлдэж байв. За яахав өнөөдөр балайрал, тэнэгэрхэл газар авч байгаа үед ийм шүлэг байг. Уншиг. Харин алтан тайзнаас дуулна гэдэг “Ай ай хө зээ хөө” гээд аялгуулан, марзагнан дуулах нь арай хэтэрсэн явдал байлаа. Зохиогч нь нутагтаа нэртэй бололтой, жигтэйхэн уухайлан алга ташуулж байв. Түүнийг нэрийг ч сонсохыг хүссэнгүй, авьяастай шүү гэж ам амандаа шагшина. Үүнийг би нийслэлийн ойролцоо оршдог аймгийн театрын тайзнаас сонссон. Ийм шүлгэнд ая хийж л байдаг. Гарт тааралдсан нь энэ. Тиймээс хэлж байгаа юм. Ийм юмс захаас аван байна. Гоо сайхан хэрэггүй гэдэг энэ үг мунхарал, булай зүйл, балайралд хүргэнэ шүү. Ийм юмыг тайлбарлах ч утгагүй. Гэхдээ мэдэх ёстой, хүргэх ёстой. Ийм л үгтэй дуу шүү дээ. Та ч сонссон байх, одоо ч дуулдаг биз, ирээдүйд ч дуулах биз. Ингэх бүр монголыг минь, монгол хүнийг гахай нохой шиг болгосон дууг жуулчлалаар ирсэн гадаадынхан сонсож л байгаа. Гоо сайхны наад захын төслөөлөлгүй хөтөч, орчуулагч хөөр бах болгон инээж байгаад орчуулж өгч байгаа. Бидний оюуны таашаал, ийм л болж...

Шүлэг болгоноос ариун дээд эрхмийг шаардах аргагүй. Зохист харьцаа, зохист байршил, зохист хандлага, зохист үзэл, зохист хэм хэмжээ юм даа. Гоо сайхныг хоосон сүржирхэл, тунхаглал ч болгох аргагүй. Энэ дууны үгийг уншаад та намайг хүлцэн зөвшөөрнө гэдэгт гүнээ итгэж байна. Муу бичиж болно, муухай бичиж болохгүй. Монголоо, монгол эрийг алдаршуулсан “Монгол ходоод” гэдэг тэр дуу нь ийм үгтэй.

МОНГОЛ ХОДООД

Тав хонсгийн өл тэвчдэг
Тарган хонины ууц шингээдэг
Тэглээ гээд тэсэрдэггүй ходоод
Тээр болж зовоодоггүй ходоод
Нанчид архийг сордог ходоод
Найруулсан спиртийг хусдаг ходоод
Гаднын нөлөө тоодоггүй ходоод
Гарын ая даадаг ходоод
Тавагтай махыг дор нь нялдаг
Тарваганы боодогийг усаар даруулдаг
Тааралдсан архиа залгин залгисаар
Тас үсрэн талийдаг ходоод оо
Найрын хойморт найгадаг ходоод
Намрын айргийг цөлдөг ходоод
Ихэдлээ гээд бялуурдаггүй ходоод
Илүү тэнгэртэй чонын ходоод оо
Тив далайд цуутай ходоод
Дэлхийд ховорхон монгол ходоод
Үнэхээр бидний буян сав
Үлгэрийн юм шиг монгол ходоод оо
Ай ай хө зэ ээ хө
Монгол ходоод мину зэ

Үнэхээр ч толгой нь дүүрэхгүй, ходоод нь тэсрэх шахам дүүрээд байгаа өнөө үед болох ч юм уу? Ай бурхан минь, би л лав чихээ бөглөмөөр байна.

Эцэст нь хэлэхэд Галсансүхийн шүлэг. Бурханы өөдөөс “хуц” гэж байна. Пай пүү гэж бодох байх. Гэвч энэ чинь харин гоо сайхан. Үнэхээр л бүхнийг бурханд даатгаад явдаг, гэвч тэр нь буруудах тийшээ. Мөн өөр талаас харвал, бурхан гэдэг нь бурхан биш ч байж болох. Хэн нэгэн зарлигддаг, заалддаг хүнд сурталт ВВ. Маяковскийн хэлснээр “чулуун бөгстөн” ч байж мэднэ. Би шүлэг бүрээс гоо сайхан, сайн сайхан, гэрэл гэгээ шаардаагүй шүү, ийм мангуу мөр шүлэг л олон бүү гараасай гэсэндээ үүнийг тэрлэллээ.

SUMMARY

Poem is losing its taste of beauty. By ignoring beauty principles, poem is losing its value. It's fundamental that there should be a beauty standard in poem. This example shows that the researcher wants to show the significance of beauty and its value and excellence based on facts and evidence.